



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/70

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 60.1.21, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөрийг батлах тухай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны II/04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэн ажиллах "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 2023 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, гарсан үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан 39,500,000 (гучин есөн сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Тамгын газрын төсвөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2023 оны
02-дугаар сарын 06-ны өдрийн А/30 дугаар
захирамжийн хавсралт



Гэрээний Жагсаалт		
1	Сайхан Монгол ТВ	20,000,000 (хорин сая төгрөг)
2	Urug.mn	7,000,000 (долоон сая төгрөг)
3	Tsahiur.mn	7,000,000 (долоон сая төгрөг)
4	Эерэг эрдэнэт ТББ	5,500,000 (таван сая тава зуун мянган төгрөг)
Нийт үнэ		39,500,000 (гучин есөн сая таван зуун мянган төгрөг)